



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/338

Булган сум

Гадаад албан томилолтоор ажиллуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Сангийн сайдын “Гадаад албан томилолтын зардлын хэмжээ шинэчлэн батлах тухай” 2011 оны 188 дугаар тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Баасанжаргалыг 2024 оны 06 дугаар сарын 25-аас 07 дугаар сарын 06-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсад болох NEAR-ийн гишүүн орон нутгуудын Төрийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх сургалтад оролцуулсугай.

2. Гадаад томилолт болон тийзийн зардал 6,524,792 (зургаан сая таван зуун хорин дөрвөн мянга долоон зуун ерэн хоёр) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын төсвөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 20-ны/ний өдрийн А/338 дугаар
захирамжийн хавсралт

ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ /төгрөг/	Мөнгөн дүн /төгрөг/
1	2	3	4	5
1	УБ-Бусан-Сөүл-УБ тийзний зардал	1 хүн	1,791,000	1,791,000
2	Томилолт 1 хүн	7 хоног	7*200 доллар	4,733,792
	Нийт дүн			6,524,792

Жич:

1 доллар = 3,381.28

/2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Монгол банкны хаалтын ханш/